



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/105

Улаанбаатар хот

Шинжээч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Патентийн тухай хуулийн 13 дугаар 13.3 дахь хэсэг, “Заан Фүүдс” ХХК-иас ирүүлсэн няцаасан нотолгоог тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барааны тэмдгийн шинжээч Л.Гэрэлмаа, Б.Оргилмаа, Г.Буяндэлгэр нарыг “Оюуны өмчийн мэдээлэл”-ийн 2020 оны 02 дугаар сарын хэвлэлд нийтлэгдсэн “Golden gobi Гэр набор” нэртэй 3836 дугаар бүхий бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт дахин шүүлт хийх шинжээчээр томилсугай.

2. Шинжээчийн дүгнэлтийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны дотор гаргаж, танилцуулахыг шинжээч Л.Гэрэлмаа, Б.Оргилмаа, Г.Буяндэлгэр нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аж үйлдвэрийн өмчийн хэлтсийн дарга /С.Урангэрэл/-д даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР

000517